

## **ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан төлөвлөлтийн зарчим шаардлагыг баримтлан, бодлогын баримт бичиг боловсруулах цаглаварын дагуу аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл төлөвлөгөө, Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөрт туссан бодлого, арга хэмжээнд үндэслэн хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулахаар Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн саналыг нийгмийн хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор нь эрэмбэлэн үйл ажиллагаа болгон тусгалаа.

Мөн иргэдээс “Дундговь-Асуудал шийдэл” пейж хуудсаар ирүүлсэн саналуудыг чиглэл чиглэлээр нь холбогдох бодлогуудад тусгасан.

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд санал авахаар “Асуудал - Шийдэл” нээлттэй олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр танхимаар болон цахимаар зохион байгуулж, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцууллаа.

Хэлэлцүүлгийг цахимаар 21,100 иргэн үзэж, танхимаар 200 орчим иргэн оролцсон бөгөөд бичгээр 27, биечлэн 13, цахимаар 79, нийт 119 иргэн төсөлтэй холбоотой санал ирүүлснийг нягтлан үзэж хөтөлбөрт чиглэл тус бүрээр нь нэгтгэн орууллаа.

Бүсчилсэн хөгжил-Дундговийн сэргэлтийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого, байгаль орчны бодлого зэрэг 5 бодлогын 26 чиглэлийн хүрээнд нийт 130 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусган, орон нутагт хэрэгжих 13 дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгалаа. Үүнд:

- Шинэ гудамж-Шинэ хороолол
- Сумдад инженерийн дэд бүтэц бүхий сервер центр хөтөлбөр
- Эко аймаг (Ногоон байгууламж, Хог хаягдал)
- Цахим аймаг
- Хүний нөөц
- Байгалийн ухаан
- Математик
- Англи хэл

Оюунлаг Дундговь

Хүүхэд хөгжил хамгааллын хөтөлбөр

Ганц бие болон өрх толгойлсон эцэг эхэд ээлтэй хөтөлбөр

Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр

Малчид тариаланчдын залгамж халааг бэлтгэх хөтөлбөр

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА**

<b>№</b>	<b>Бодлого</b>	<b>Үйл ажиллагаа</b>	<b>Үйл ажиллагааны тоо</b>
1	БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ- ДУНДГОВИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-20	1. Эдийн засаг	3
		2. Дэд бүтэц	7
		3. Авто зам	6
		4. Эрчим хүч	4
2	ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-49	1. Боловсрол	5
		2. Эрүүл мэнд	5
		3.Биеийн тамир, спорт	5
		4.Хүүхэд, гэр бүл	8
		5.Соёл урлаг	6
		6.Хөдөлмөр эрхлэлт	4
		7.Ахмад настан	6
		8.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	4
		9.Залуучууд	6
3	ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-36	1.Төсөв санхүү, татвар	3
		2.Хүнс, хөдөө аж ахуй	14
		3.Жижиг дунд үйлдвэрлэл	9
		4.Аялал жуулчлал	4
		5.Уул уурхай	6
4	ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-17	1.Төрийн алба	3
		2.Иргэдэд ойр төрийн шуурхай үйлчилгээ	3

		3.Гэмт хэрэгтэй тэмцэх	4
		4.Гамшгаас хамгаалах	2
		Батлан хамгаалах	3
		Орон нутгийн өмч	2
5	БАЙГАЛЬ ОРЧНЫ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-8	Биологийн олон янз байдал	2
		Эко орчин	6
<b>НЭГДСЭН ДҮН</b>			<b>130</b>

## НЭГ.БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ-ДУНДГОВИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**Зорилго:** Эдийн засгийн өрсөлдөх чадвар нэмэгдсэн, иргэд амьдрахад таатай, эрүүл, аюулгүй орчин бүхий дэд бүтэц хөгжсөн аймаг болно.

### Эдийн засаг

#### ТЕЗ-ийн үр дүн:

**1.1.Аймгийн өрсөлдөх чадварын индекс өснө.**

#### Хөтөлбөрийн үр дүн:

**1.1.1.Эдийн засгийн үзүүлэлт нэмэгдэнэ**

**Дэд бүтцийн үзүүлэлт нэмэгдэнэ**

**Замын шинэчлэл хийгдэнэ**

**Эрчим хүчний найдвартай үйл ажиллагаа сайжирна.**

#### Үйл ажиллагаа:

1.1.1.1 Говийн бүсийг усаар хангах "Орхон-Онги" төслийн бүсэд ногдох хэсгийг байгуулах /БХҮБ-3.1.16, ЗГҮАХ-3.4.3.11,НМХ-6.1.1/

1.1.1.2 Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах /БХҮБ-3.6.7, ЗГҮАХ-3.3.5.12, НМХ-6.1.2/

1.1.1.3 Худалдаа үйлчилгээ, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх "Хөгжлийн 4 замын уулзвар" бий болгох /БХҮБ-3.6.14, ЗГҮАХ-3.3.5.12, НМХ-6.1.3/

1.1.1.4 **Говийн бүсийн уул уурхайн салбарын мах, хүнсний хэрэгцээг хангах үйлдвэр байгуулах**

### Дэд бүтэц

1.2.1 Дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх /ЗГҮАХ-3.3.3.27, НМХ-6.1.11, 6.2.1/

1.2.3 "Шинэ гудамж, шинэ хороолол" хөтөлбөр хэрэгжүүлэх /НХМ-1.1.2, 1.1.4, 6.2.9/

1.2.4 Инженерийн дэд бүтэц бүхий сервес центр төсөл хэрэгжүүлэх /НХМ- 6.2.9, 6.2.10/

1.2.5 Нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилтийг нэмэгдүүлэх /НХМ- 6.3.11/

1.2.6 Сумдад шаардлага хангасан ахуйн үйлчилгээний барилгыг засварлах, байгуулах НМХ-6.3.12

1.2.7 "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийг аймаг, сумдад хэрэгжүүлэх /НМХ1.1.1/

1.2.8 Сумдыг 5G сүлжээнд холбож, алслагдсан багуудыг үүрэн телефоны сүлжээтэй болгох

### **Авто зам**

- 1.3.1 Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх ажилд хамтарч ажиллах /НМХ-6.1.8/
- 1.3.2 Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн авто зам барих ажилд хамтарч ажиллах /НМХ-6.1.7/
- 1.3.5 Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын их засвар хийх /НМХ-6.1.8/
- 1.3.6 Зарим сумдыг аймгийн төв болон улсын чанартай авто замтай хатуу хучилттай авто замаар холбох /НМХ-6.1.9/
- 1.3.7 Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын чанарыг сайжруулж, хот доторх авто замыг холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх /НМХ-6.2.4, 6.2.5, 6.2.7/

### **Эрчим хүч**

- 1.4.1 Мандалговь шинэ суурьшлын бүс болон шаардлагатай сумдыг 0,6кВ болон 0.4кВ-ийн хуваарилах сүлжээ бүхий цахилгаан хангамжаар бүрэн хангах /НМХ-6.2.2/
- 1.4.2 Говийн бүсийн нар, салхины нөөцийг ашиглан, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний станцуудыг байгуулах /НМХ-6.1.4/,/ЗГҮАХ-3.3.3.27/
- 1.4.3 Салхитын уурхайгаас Их газрын чулуу, байгалийн задгай театр хүртэл эрчим хүчний шугам татах /НМХ-6.1.12/
- 1.4.4 Дундговь аймгийн төвийг цахилгаан эрчим хүчээр хангадаг Төв дэд станцыг 35/10кВ хүчдэлийн 2\*10000кВА чадалтай болгож хүчин чадлыг нэмэгдүүлэх /ЗГҮАХ-3.3.3.5./

## **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО**

**Зорилго:** Эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл чийрэг иргэнийг хөгжүүлнэ.

### **Боловсрол**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

Боловсролын чанар сайжирна.

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Багшийн ур чадвар сайжирна.

#### **Үйл ажиллагаа:**

- 2.1.1 “Оюунлаг Дундговь” болон “Байгалийн ухаан” “Математик”, “Англи хэл”, дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх МХ 1.3.5, 1.3.4, 1.3.6, 1.3.9, 1.3.10.
- 2.1.2 Олон Улсын жишигт нийцсэн бүсийн хэмжээний ерөнхий боловсролын сургууль байгуулах МХ 1.3.1
- 2.1.3 **Политехник коллежийн сургалтын орчныг сайжруулж, бодлогыг говийн бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх** МХ 1.3.2

- 2.1.4 Аймгийн хэмжээнд зайлшгүй шаардлагатай цэцэрлэг, сургууль, сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барих, засварлах 6.3.4-6.3.6 хүртэл МХ 1.3.7, 1.3.8
- 2.1.5. Боловсролын үйлчилгээнд хамрагдах тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай болон эрсдэлт бүлгийн суралцагчдад дэмжлэг үзүүлж, боловсролд тэгш хамруулах МХ 1.4.4

## **Эрүүл мэнд**

### **ТЕЗ-ийн үр дүн:**

Хүн амын өвчлөл буурна.

### **Хөтөлбөрийн үр дүн:**

Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоо нэмэгдэнэ.

### **Үйл ажиллагаа:**

- 2.2.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх НМХ 1.2.3
- 2.2.2. Эмч, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэх (НМХ 1.2.7, ЗГҮАХ 2.3.4.1-2.3.4.3)
- 2.2.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх (НМХ1,2,1, 1.4.35 ЗГҮАХ 2.3.2.6, 2.3.2.2, 2.3.2.8, 2.3.3.1, 2.3.2.3, 2.3.2.5)
- 2.2.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх (НМХ 1.2.1, 1.2.2, 1.2.5, 1.2.6, ЗГҮАХ 2.3.1.1-2.1.3)
- 2.2.5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх (НМХ1.2.4, 1.4.35)

## **Биеийн тамир, спорт**

### **ТЕЗ-ийн үр дүн:**

Эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг иргэдийн тоо нэмэгдэнэ.

### **Хөтөлбөрийн үр дүн:**

Нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмж сайжирна.

### **Үйл ажиллагаа:**

- 2.3.1. Мандалговь хотод усан бассейн бүхий спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулах НМХ 1.7.1
- 2.3.2. Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн хийх, явган алхах, унадаг дугуйн зориулалтын зам талбайг нэмэгдүүлэх НМХ 1.7.2
- 2.3.3. Дундговь аймгийн “Бага Олимп” спортын наадмыг 2 жил тутам зохион байгуулах НМХ 1.7.3
- 2.3.4. Улс бүс, аймгийн аварга шалгаруулах, үндэсний болон олимпын төрлийн

- спортын тэмцээнийг зохион байгуулах НМХ 1.7.4  
2.3.5. Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх НМХ 1.6.5

### **Хүүхэд, гэр бүл**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

**Тогтвортой**, аз жаргалтай, **ирээдүйд итгэлтэй хүүхэд**, гэр бүлийг төлөвшүүлэх, тэдний эрх хамгаалагдана.

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Хүүхэд, гэр бүлд ээлтэй тэгш боломж бүрдэнэ.

#### **Үйл ажиллагаа:**

- 2.4.1. Гэр бүл, Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх / НМХ- 1.4.1, 1.4.7ЗГМХ-2.1.1.6/
- 2.4.2. Цэцэрлэг сургуулийн үдийн хоолны шим тэжээлийг сайжруулах НМХ1.4.5
- 2.4.3. Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1.4.5
- 2.4.4. Ганц бие болон өрх толгойлсон эцэг эхэд ээлтэй бодлого хэрэгжүүлэх 1.4.8
- 2.4.5. Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих бодлого хэрэгжүүлэх 1.4.10
- 2.4.6. Цэцэрлэг, сургуулийн орчинг бүрэн камержуулах 1.4.6
- 2.4.7. Бүрдийн уянга зусланг шинэчлэн засварлах /НМХ-6.1.10
- 2.4.8. Хүүхдийн паркийн үйл ажиллагааг сайжруулах / Асуудал шийдэл/

### **Соёл урлаг**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

Үндэсний соёлын биет болон биет бус өвлөн уламжлагчид нэмэгдэнэ.

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Бүх нийтийн соёлын боловсрол дээшилнэ.

#### **Үйл ажиллагаа:**

- 2.5.1. Төв халхын дуулалт жүжгийн Театрын барилгыг ашиглалтад оруулах МХ 1.6.1
- 2.5.2. Дуу хуурын өлгий нутгаа Олон Улс болон Улсын хэмжээнд сурталчлан таниулж, Уртын дууч, морин хуурчдын III их наадмыг зохион байгуулах МХ 1.6.2
- 2.5.3. Дуу хуурын өлгий нутгийн өв соёлыг хадгалан, өвлүүлэх үүднээс иргэдийн дунд урлагийн наадмыг зохион байгуулах МХ 1.6.4
- 2.5.4. Улс, аймгийн хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх, хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ЗГҮАХ 3.3.6.4
- 2.5.5. Дуу хуурын өлгий нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулах ЗГҮАХ 3.3.6.1, 3.3.6.13

## **Хөдөлмөр эрхлэлт**

### **ТЕЗ-ийн үр дүн:**

Ажилгүйдлийн түвшинг буурна.

### **Хөтөлбөрийн үр дүн:**

Байнгын шинэ ажлын байрыг нэмэгдэнэ. /НМХ 1.4.41/

### **Үйл ажиллагаа:**

- 2.6.1. Аж ахуй эрхлэх, малжуулах зэргээр иргэдийн орлогын өсөлтийг дэмжих арга хэмжээг авч ажиллах /НМ хөтөлбөр -1.5.1, 1.4.18, 1.4.32/
- 2.6.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрамжилж буй иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх /НМ хөтөлбөр -1.5.2, ЗГҮАХ -2.1.1.28/
- 2.6.3. Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачилгыг хөнгөлөлттэй зээлээр дэмжих / НМ хөтөлбөр 1.5.3, 1.5.4, 1.5.6, ЗГ- 2.1.2.1/
- 2.6.4. Иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлэх /НМ хөтөлбөр- 1.4.19, 1.5.5/

## **Ахмад настан**

### **ТЕЗ-ийн үр дүн:**

Эрүүл амьдралын хэв маягтай, идэвхтэй ахмад настан нэмэгдэнэ.

### **Хөтөлбөрийн үр дүн:**

Ахмадын нийгмийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

### **Үйл ажиллагаа:**

- 2.7.1. Аймагт ахмадын сувилал байгуулж, орон нутагтаа сувилуулах боломжийг бүрдүүлэх /НМ хөтөлбөр -1.4.20/
- 2.7.2. Ахмадын урлаг, спортын наадмыг зохион байгуулах /НМ хөтөлбөр -1.4.23/
- 2.7.3. Сумын ахмадын хорооны дарга нарын урамшууллыг үе шаттайгаар нэмэгдүүлэх /НМ хөтөлбөр-1.4.26/
- 2.7.4. Түрээсийн орон сууцны хөтөлбөрт ахмадуудыг хамруулан, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэх /НМ хөтөлбөр -1.4.21/
- 2.7.5. Аймгийн төвд “Ахмадын эмнэлэг” байгуулах. /НМ хөтөлбөр -1.4.25/
- 2.7.6. 60-аас дээш насны ахмад настануудыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх төв байгуулах /НМ хөтөлбөр -1.4.24, 1.4.27

## **Хөгжлийн бэрхшээлтэй иргэн**

### **ТЕЗ-ийн үр дүн:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх, оролцоо нэмэгдэнэ.

### **Хөтөлбөрийн үр дүн:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох хүртээмж сайжирна.

### **Үйл ажиллагаа:**

- 2.8.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартын хэрэгжилтийг хангуулах /НМ хөтөлбөр-1.4.38, ЗГ -2.1.1.24/
- 2.8.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмчилгээ, оношилгоо, тусламж, үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх /НМ хөтөлбөр 1.4.40, ЗГ- 2.1.1.26/



2.8.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд асарч буй иргэд рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах /ЗГ 2.1.1.23/

2.8.4. Төрийн албан хаагч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх /найруулах/

### **Залуучууд**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

Залуучуудын нийгмийн идэвх оролцоо нэмэгдэнэ.

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Залуучуудын хөгжих орчин нөхцөл сайжирна.

#### **Үйл ажиллагаа:**

2.9.1. Цагийн ажлын зуучлалыг E-Student цэсээр дамжуулан зохион байгуулах НМХ 1.4.7

2.9.2. Хөдөлмөр эрхлэх боломжуудыг нэмэгдүүлж, шинээр ажлын байр бий болгох НМХ 1.4.9

2.9.3. Залуучуудын гарааны бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх НМХ 1.4.10, 1.4.11 ЗГҮАХ 2.1.1.35,

2.9.4. Орчин үеийн стандартад нийцсэн кино театр байгуулах НМХ 1.4.12

2.9.5. Залуучуудын хөгжлийн төв байгуулах /Найруулах/ НМХ 1.4.13

2.9.6. Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулах

### **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО**

Хөрөнгө оруулалтын орчинг сайжруулан, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.

### **Төсөв санхүү, татвар**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

Төсвийн орлогын бааз суурь нэмэгдэнэ.

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Хариуцлагатай татвар төлөгчийн тоо нэмэгдэнэ.

#### **Үйл ажиллагаа**

2.1.2.1 Хариуцлагатай татвар төлөгч төслийг хэрэгжүүлж татвар төлөгчдийг эрсдлээс урьдчилан сэргийлж, татварын хуулийн хэрэгжилтийг иргэн, хуулийн этгээдэд жигд хангуулах

2.1.2.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах

2.1.2.3 Аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрүүлэлтийг нэмэгдүүлэх

2.1.2.4 Төрийн сангийн төлбөр тооцооны хяналтыг сайжруулж Эрсдэлгүй харилцагч сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

## Хүнс, хөдөө аж ахуй

### ТЭЗ-ийн үр дүн:

Хөдөө аж ахуйн салбар шинэ технологи, инновацид суурилан, үр ашигтай бизнесийг дэмжснээр жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, аж ахуй нэгжийн тоо нэмэгдэнэ.

### Хөтөлбөрийн үр дүн:

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэнэ

Малын халдварт өвчний гаралт буурна

Өрсөлдөх чадвартай бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийн ажлын байрыг нэмэгдэнэ

### Үйл ажиллагаа:

- 3.2.1. Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий мах боловсруулах үйлдвэрийг байгуулах
- 3.2.2 Мал аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх /НМХ-2.1.2, 2.1.6, ЗГҮАХ 3.3.4.11, ЗГҮАХ 3.3.4//НМХ-3.7.2, ЗГҮАХ 3.3.4.21, /НМХ-3.7.3, ЗГҮАХ 3.3.4.21/, НМХ-1.4.28, 1.4.29, ЗГҮАХ 3.3.4.21/, НМХ-1.4.30, ЗГҮАХ 3.3.4.16/

Говийн бүсийн гойд ашиг шимт цөм сүргийг бий болгох /НМХ-2.1.2, 2.1.6, ЗГҮАХ 3.3.4.11, ЗГҮАХ 3.3.4/

3.2.2. Бэлчээрийн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /НМХ-2.1.4, ЗГҮАХ 3.3.4.11/

3.2.3. Сумдад стандартын шаардлага хангасан өвс, тэжээлийн агуулах шинээр байгуулах /НМХ-2.1.7, ЗГҮАХ 3.3.4.8/

3.2.4. Хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалах талбайн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх /НМХ-2.1.8, ЗГҮАХ 3.3.4.13, 3.3.4.20, 3.3.4.22/

3.2.5 Хүнсний аюулгүй байдлын эрсдлийг бууруулах

3.2.5. Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх /НМХ-3.7.2, ЗГҮАХ 3.3.4.21/

3.2.6. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх /НМХ-3.7.3, ЗГҮАХ 3.3.4.21/

3.2.8. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх бодлого хэрэгжүүлэх /НМХ-2.1.5, ЗГҮАХ 3.3.4.1, 3.3.4.32/

3.2.9. Малчдад тэжээлийн ургамал тариалахад дэмжлэг үзүүлэх /НМХ-1.4.28, 1.4.29, ЗГҮАХ 3.3.4.21/

3.2.10. Малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах цех байгуулахад дэмжлэг үзүүлэх /НМХ-1.4.32 НМХ-2.1.9/

3.2.11. Арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах /НМХ-2.1.10/

3.2.12. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн 4 улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах боломжийг бүрдүүлэх /НМХ-2.1.11/

3.2.13. Мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах /НМХ-1.4.30, ЗГҮАХ 3.3.4.16/

3.2.14. Малын эмч, мал зүйч мэргэжилтэнг үе шаттайгаар бэлтгэх /НМХ-1.4.30, ЗГҮАХ 3.3.4.16/

### Жижиг, дунд үйлдвэрлэл

### Үйл ажиллагаа:

3.4.1. Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий хүнсний үйлдвэрийг байгуулах

3.4.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх /НМХ-3.2.1, ЗГҮАХ-2.1.3.12/

- 3.4.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд нэвтрүүлэх үзэсгэлэн худалдааг зохион байгуулж үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжин, сурталчилах /НМХ-3.1.3/
- 3.4.3. Ажлын байрыг шинээр бий болгосон бүс, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжийг дэмжих /НМХ-3.2.3/
- 3.4.4. Инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх /НМХ-3.2.5/
- 3.4.5. Аймгийн хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр стандартад нийцсэн үйлчилгээг дэмжих /НМХ-3.2.7/
- 3.4.6. Гудамж талбайн нийтийн эзэмшлийн хэсэг, цэцэрлэгт хүрээлэнд үйлчилгээ эрхлэх боломжийг дэмжиж ажиллах /НМХ-3.1.1/
- 3.4.7. Мандалговь хотод бизнес инкубатор төв байгуулах /НМХ-3.1.2, 3.2.4/
- 3.4.8. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоо байгуулах /НМХ-2.1.3 ЗГҮАХ-3.3.4.4/
- 3.4.9. Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүнийг Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх боломжийг бүрдүүлэх /НМХ- 3.2.2/

### **Аялал жуулчлал**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

Аймагт зочлох гадаад, дотоодын жуулчдын тоо нэмэгдэнэ.

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.

#### **Үйл ажиллагаа**

- 3.5.1. Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил нутгийн онцлох бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах эвент арга хэмжээг тогтмолжуулах /ЗГҮАХ-3.3.5.3, НМХ 3.3.4/
- 3.5.2. Байгалийн өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт газрыг түшиглэн аялал жуулчлалын төвийг байгуулах /НМХ-3.3.5, 3.3.9/
- 3.5.3. Аялал жуулчлалын бүс дэх иргэн, аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэлийн аймаг, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлэхэд төсөл хөтөлбөр, ногоон зээлээр бодлого баримтлах /НМХ 3.3.2, 3.3.3, 3.3.6/
- 3.5.4. Аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа марктенгийн ажлыг эрчимжүүлж, орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах /ЗГҮАХ-3.3.5.2, НМХ 3.3.5, 3.3.7/

### **Уул уурхай**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

Уул уурхайн төслүүдийн орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр нэмэгдэнэ. /ЗГҮАХ-3.3.1.1, 3.3.1.5, НМХ-3.2.3, 3.2.8/

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Хариуцлагатай уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжийг дэмжинэ. /ЗГҮАХ-3.3.1.1,/

#### **Үйл ажиллагаа:**

- 3.6.1. Хариуцлагатай уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэрлэл байгуулахтай

холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах

- 3.6.2 Орон нутгийн байгалийн баялаг, ашигт малтмалд түшиглэсэн барилгын материалын үйлдвэр байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх /ЗГҮАХ-3.3.1.5, НМХ- 3.2.9/
- 3.6.3. Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд жилд 1-ээс доошгүй удаа хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх /ЗГҮАХ-3.3.1.1, НМХ-3.2.3, 3.2.8, /
- 3.6.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын төслийг дэмжиж ажиллах
- 3.6.4. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулах, замын засвар арчилгааг хийж багтлагдсан маршрутыг дагаж мөрдөх ажлыг зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах

## **ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО**

**Зорилго:** Төрийн үйлчилгээг цахимжуулж, хүртээмжтэй, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлнэ.

### **Төрийн алба**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

Төрийн албаны хүний нөөц тогтвортой байдал хангагдана. +

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанар сайжирна.

#### **Үйл ажиллагаа:**

- 4.1.1 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх (НМХ 3.4.1, 3.4.4, 3.5.2, 3.5.1)
- 4.1.2 Төрийн албан хаагчийн нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах (НМХ 3.4.2, 3.4.4, 3.4.6)
- 4.1.3 Төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга хариуцлагыг сайжруулах (НМХ 3.4.1, 3.4.4, 3.5.2, 3.5.1)

### **Иргэдэд ойр төрийн үйлчилгээ:**

#### **ТЕЗ-ийн үр дүн:**

**Төрийн үйлчилгээ цахимжина.**

#### **Хөтөлбөрийн үр дүн:**

Иргэдийн цахим ур чадвар дээшилнэ.

**Үйл ажиллагаа:**

- 4.2.1 Цахим Дундговь хөтөлбөр хэрэгжүүлэх
- 4.2.2 Цахим хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх
- 4.2.3 Төрийн архиваас иргэдэд үзүүлж буй лавлагаа, үйлчилгээг цахимд шилжүүлэх./ЗГҮАХ-4.2.2/
- 4.2.4 Иргэд, олон нийтэд төрийн үйл ажиллагааны мэдээллийг хүртээмжтэй хүргэх

**Гэмт хэрэгтэй тэмцэх:**

**ТЕЗ-ийн үр дүн:**

Иргэд амар тайван аюулгүй амьдрах орчин бүрдэнэ. (НМХ-ийн 3.5.4 дахь заалт)

**Хөтөлбөрийн үр дүн:**

Бүртгэгдсэн гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэнэ. (НМХ-ийн 3.4.5 дахь заалт)

**Үйл ажиллагаа:**

- 4.3.1. Иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулж нэмэгдүүлэх (НМХ-ийн 3.5.3)
- 4.3.2 Мандалговь хотын камерын хяналтын дэд төв байгуулах (НМХ-ийн 3.5.4)
- 4.3.3. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх (НМХ-ийн 3.4.5 дахь заалт)
- 4.3.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх (НМХ-ийн 3.5.3)

**Гамшгаас хамгаалах:**

**ТЕЗ-ийн үр дүн:**

Аймгийн гамшгийн эрсдэл буурна

**Хөтөлбөрийн үр дүн:**

Аймгийн хэмжээнд байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, осолтой тэмцэх бэлтгэл бэлэн байдал нэмэгдэнэ

**Үйл ажиллагаа:**

- 4.4.1. Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, болзошгүй гарз хохирол эрсдэлийг бууруулах
- 4.4.2. Говь-Угтаал суманд эрэн хайх аврах бүлгийг шинээр байгуулах

**Батлан хамгаалах**

**ТЕЗ-ийн үр дүн:**

"Сөрөн тэсвэрлэх чадавх-Батлан хамгаалах тогтолцоо" зорилтын хүрээнд орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдал хангана. (ЗГҮАХ- 4.4.3.3)

**Хөтөлбөрийн үр дүн:**

Дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болно.

**Үйл ажиллагаа:**

- 4.5.1. Дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох хүрээнд иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх
- 4.5.2. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангах
- 4.5.3. "Эх орны дуудлага-Эр цэргийн алба" зорилтын хүрээнд батлан хамгаалах үйл хэрэгт иргэдийн оролцоо нэмэгдүүлэх /НМХ-ийн 9 заалт, ЗГҮАХ-ийн 2 заалт/

## Орон нутгийн өмч

### ТЕЗ-ийн үр дүн:

Орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдэнэ.

### Хөтөлбөрийн үр дүн:

Өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалт сайжирч, төсвийн сахилга хариуцлага дээшилнэ.

### Үйл ажиллагаа:

- 4.6.1. Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, хамаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, өмчийн бүрэн бүтэн байдалд тавих хяналт шалгалтыг хэрэгжүүлэх
- 4.6.2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

## ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**Зорилго: Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамж бүхий ногоон хөгжлийг цогцлооно.**

### Биологийн олон янз байдал

### ТЕЗ-ийн үр дүн:

Биологийн олон янз байдлын нөөцийг нэмэгдэнэ

### Хөтөлбөрийн үр дүн:

Агнуурын болон тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг батлуулна.

### Үйл ажиллагаа:

5.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх /ЗГҮАХ-3.4.1, 3.4.1.1, НМХ-3.7.6./

5.1.2. Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг тодорхойлж, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх

### **Эко орчин**

### ТЕЗ-ийн үр дүн:

Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин сайжирна.

### Хөтөлбөрийн үр дүн:

Хүрээлэн буй орчны бохирдол буурна.

Ногоон байгууламжийн талбайн хэмжээ нэмэгдэнэ.

Усны нөөцийн зохистой ашиглалтыг хэвшүүлэн, шаардлагад нийцсэн ундны усаар хангагдсан төв суурин газрын хүн амын эзлэх хувь нэмэгдэнэ.

### Үйл ажиллагаа:

- 5.2.1. “Эко аймаг” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх /НМХ 3,6,6/
- 5.2.2. Аймаг, сумын төвийн хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усны хайгуул судалгааг хийж, нөөцийг нэмэгдүүлэх. /МХ-3.8.5/
- 5.2.3. Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 12 эх үүсвэрт суурилуулах
- 5.2.4. Гадаргын ус ашиглалтыг нэмэгдүүлэх /НМХ-3.8.1/
- 5.2.5. Саарал усны ашиглалтыг нэмэгдүүлэх /ЗГҮАХ-3.4.1.7, МХ-3.8.2, МХ-3.8.3/
- 5.2.6. Мандалговь хотын ундны усны эх үүсвэр, өргөгч станцууд аюулгүй байдлыг хангаж, автоматжуулах

## АЖЛЫН ХЭСЭГ